



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 269


Улаанбаатар хот

「 Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгч Лувсандоржийн Амарсайханы даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн
269 дүгээр тогтоолын хавсралт



Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох иргэний мэдээлэл

№	Овог	Нэр	Регистр	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Лувсандорж	Амарсайхан	ШУ88080890	2013.04.24	98 дугаар тушаал	2/13/231/396